



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/91

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 60.1.6, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Ховд аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн хөгжлийн сангийн 4.7-д тусгагдсан Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөрүүд (“Цахим Ховд”, “Стандарттай Ховд”, “Хариуцлагатай тунгалаг төр”, “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжил”) Үйлчилгээний нэгдсэн төв байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д шилжүүлсүгэй.

2. Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 120,000,000 төгрөг /нэг зуун хорин сая/-ийг 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Багдал)-т зөвшөөрсүгэй.

3. Үйлчилгээний нэгдсэн төвийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгийг данс бүртгэлд тусгахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Баярсүх), Орон нутгийн өмчийн газар (Ш.Нохойжав)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 07 0546

Zah A/91 Kh